



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/40

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт зохицуулалт хийх тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Модны зөв ургах, тарьц бэлдэх багаж хэрэгсэл, Худагт насос авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын тамгын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

С.Отгонбаатар

(1-р дүгээр багийн Засаг дарга)

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, худалдан авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

2. Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд Модны зөв

ургах, тарьц бэлдэх багаж хэрэгсэл, Худагт насос авах ажилд 2,000,000 /хоёр сая/ төгрөгийг зарцуулсугай.

3.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний зарцуулагдах 2,000,000 /хоёр сая/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч /Л.Цэнд-Аюуш/-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Тэрбум мод үндэсний хөдөлгөөний ажлын хэсэгт, захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Гантуяа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ

